



СОЁЛ УРЛАГ, ШАШНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2022 оны 11 дугаар сарын 2-ны өдрийн
1312 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж:	
Шалгуулагч этгээдийн нэр:	
Регистрийн дугаар:	
Объектын нэр, хаяг, солбицол:	
Байгуулагдсан огноо:	
Үйл ажиллагааны чиглэл:	
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар:	

2. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан эсэх		Тайлбар	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Тийм	Үгүй		
1	1	2	3	4	5	6
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн эсэх.				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх.				
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангасан эсэх.				

4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.9	гал түймрийн аюулын үнэлгээг энэ хуулийн 18.5, 18.6, 18.7, 18.8-д заасны дагуу хийлгэсэн эсэх.			
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10	Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан эсэх.			
6	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.3	Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэлтэй эсэх.			
7	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.3	Барилга байгууламж, гэр хорооллыг гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбайтай, гал түймэр унтраах үед ашиглах усан хангамжтай байхаар төлөвлөсөн эсэх.			
8	Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралт Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм	Барилга байгууламжид улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан, актаар баталгаажсан эсэх.			
9	Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04	Заавал биелүүлэх 4-р хавсралт "Галын аюулаас хамгаалах шаардлага хангасан эсэх"			
10	Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолын хавсралт "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.3 дахь заалт	Өөрийн ажилтан бүрт галын аюулгүй байдлыг хангах талаар зааварчилгаа өгч, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан эсэх.			
11	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.6 дахь заалт	2.6. Барилга байгууламжид гал түймэр гарсан үед мэдээлэх холбоо, дохиоллын хэрэгсэл ажиллагаатай эсэх.			
12	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.15	Галын аюулгүйн шаардлагын дагуу барилга байгууламжийн мод, төмөр, хийц бүтээц,			

	дахь заалт	даавуу, хөшиг зэрэг шатамхай эд зүйлийг галд тэсвэртэй бодист түрхлэг, нэвчилгээг дүрэм заасны дагуу хийлгэсэн эсэх.				
13	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.18 дахь заалт	Барилгын дотоод өөрчлөлт, засварын үр дүнд гал унтраах автомат систем, галын дохиоллын үйлчлэх хүрээг багасгах зайлшгүй шаардлагатай тохиолдолд гал түймрийн улсын хяналтын байцаагчтай зөвшилцөж хамгаалалтгүй болсон талбайд нэмэлт гал унтраах автомат унтраагуур, мэдээлэгч суурилуулсан эсэх.				
14	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.23 дахь заалт "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.24 дэх заалт	Барилга байгууламжийн зоорийн болон хагас зоорийн давхарт үйлчилгээ явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага нь 5л-ээс бага хэмжээтэй 1 ширхэг хийн баллоныг тухайн нутаг дэвсгэрийн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн зөвшөөрөлтэйгээр ашигладаг эсэх. Эвдрэл гэмтэлтэй шатдаг хийн тоног төхөөрөмж, ахуйн зориулалттай хийн тулга болон тосон дэн, дэнлүү, зул, лааны аюулгүй байдал хангагдсан эсэх.				
15	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.35.1 дэх заалт	Барилга байгууламжийн хоорондох галын аюулгүйн зайг бараа материал хураах, автомашины зогсоол болгох зэргээр ашигладаг эсэх.				
16	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.35.2 дахь заалт	Барилга байгууламжийн ойр орчимд хялбар авалцан асах шатамхай шингэн, шахсан болон шингэрүүлсэн хийн савыг хяналтгүйгээр орхидог эсэх.				
17	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.35.4 дэх заалт	Зоорийн болон хагас зоорийн давхарт дүрмээр зөвшөөрөгдсөнөөс бусад шатамхай болон хялбар авалцан асах шингэн, дарь, тэсэрч дэлбэрэх бодис, материал, хийн баллон зэрэг галын аюултай бодис, материалыг хадгалдаг эсэх.				
18	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.35.4 дэх заалт	Цахилгаан урсдаг шатны өмнөх талбай, шатны талбай				

	дүрэм"-ийн 2.35.6 дахь заалт	зэрэгт худалдаа болон бусад ажил, үйлчилгээ явуулах, агуулахын зориулалтаар ашигладаг эсэх.				
19	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.35.7 дахь заалт	Зоорийн болон хагас зоорийн давхраас бие даасан гарцгүй, эсхүл гарц нь барилгын үндсэн шатнаас галаас хамгаалах хаалтаар тусгаарлагдаагүй тохиолдолд тухайн барилга байгууламжид аж ахуйн зориулалтын үйлдвэрлэл явуулахыг хориглоно.				
20	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2.35.8 дахь заалт	2.35.18. олон хүн байрлах барилгын дотоод засал чимэглэлд шаталтын нөлөөгөөр амьсгал боогдуулах хорт хий ялгаруулдаг барилгын материал ашигладаг эсэх.				
21	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.1 дэх заалт	Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж байгаа байгууллага нь арга хэмжээ, үзвэр үйлчилгээг зохион байгуулахаас өмнө тухайн объектын галын аюулгүй байдлыг шалгаж, аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.				
22	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.2 дахь заалт	Өрөө, танхимд үзэсгэлэн гаргах зорилгоор барилгын дотоод байршил, тоног төхөөрөмжид өөрчлөлт хийхдээ шат, аврах бусад гарц руу очих зам гарцыг хаах, нэвтрэх зайг багасгахыг хориглоно.				
23	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.3 дахь заалт	Олон хүн нэг дор байрлах барилга байгууламж нь цахилгаан тасарсан тохиолдолд ослын гэрэлтүүлэг, дуут мэдээлэгчтэй байх бөгөөд объектын онцлог, багтаамж, барилгад байгаа хүмүүсийн тооноос хамааруулан тооцож гар чийдэн байрлуулна. Барилга байгууламжийн харуул хамгаалалтын бүрэлдэхүүн нь иж бүрэн гэрэлтүүлэх хэрэгслээр хангагдсан эсэх.				
24	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.4 дэх	Олон хүн байрлах барилгын шал болон шатанд дэвссэн хивс, хивсэнцэр нь сайтар				

	заалт	бэхлэгдсэн эсэх.				
25	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.5 дахь заалт	ЗАврах зам, гарцад байрлах "аврах гарц", "аврах хаалга" зэрэг гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь тэжээлд байнга залгаж асаалттай байх бөгөөд үзвэрийн газарт танхимаас хүмүүс гарсны дараа унтрааж болно.				
26	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.6 дахь заалт	Аврах зам, гарцын гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь цахилгаан тасармагц ослын тэжээлээс (өөр эх үүсвэрээс) тэжээгдэн автоматаар асч байхаар тоноглогдсон эсэх.				
27	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.7 дахь заалт	Талбайн болон тайзны гэрэлтүүлгийг суурилуулан ашиглах тохиолдолд шатдаг материалд ойр байрлуулахыг хориглоно.				
28	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.10 дахь заалт	Нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах үед байр, танхим болон тайзны үзлэгийг тогтмол хийж, арга хэмжээ дууссаны дараа барилга байгууламжид дахин үзлэг хийж жижүүрт хүлээлгэн өгнө.				
29	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.13 дахь заалт	Галын аюулгүйн дүрэмд тусгайлан зөвшөөрөөгүйгээс бусад тохиолдолд аврах зам, гарцын дагуу байрлах хаалга нь барилгаас гарах чиглэлийн дагуу онгойхоор төлөвлөгдсөн байна.				
30	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.16 дахь заалт	Гадаадын иргэн, аж ахуй нэгж, байгууллага хоёр улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу, эсхүл бие даан үзэсгэлэн, үзвэр, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахдаа Монгол Улсад мөрдөж байгаа галын аюулгүй байдлын дүрмийн шаардлагыг дагаж мөрдөнө				
31	"Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 3.17 дахь заалт	Соёл урлаг, спорт, түүх дурсгал, шашны байгууллага, үзвэрийн газар нээлтийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхээ мэргэжлийн байгууллагаар шалгуулж илэрсэн зөрчлийг арилгасан эсэх.				

32	“Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийн 8.25 дахь заалт	Барилгын гадна галын гидрантыг байнга бэлэн байдалд байлгаж, өвөл хөлдөхөөс хамгаалан дулаалж цэвэрлэсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн талбайн 50 м доторх гадна галын гидрантын бүрэн бүтэн байдалд хяналт тавьсан эсэх.				
33	“Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийн 8.27 дахь заалт	8.27. Барилгын доторх галын гидрант (галын кран) нь байнгын даралттай, хэвийн ажиллагаатай эсэх.				
34	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143 : 2013 “Гэрэлтэх тэмдгийг байрлуулахад тавих шаардлага”-ын 6.1 дэх заалт	Байшин, барилга, тээврийн хэрэгсэл, объект болон тэдгээрийн тусдаа байрлах хэсгийн доторхи байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг нь дараах шаардлагыг хангасан байна: - Гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээний гадаргууны гэрэлтүүлэг 25 лк-аас багагүй байх; - Цахилгааны эх үүсвэртэй гэрэлтүүлэгчийн гадаргууг гэрэлтүүлэх хугацаа 15 минутаас багагүй байх; - Гэрэлтүүлгийн эх үүсвэрийн байнгын ажиллагаанд сар бүр үзлэг хийж шаардлагатай үед цэнэглэх болон шаардлага хангаагүй эх үүсвэрийг сольж байна.				
35	Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143 : 2013 “Гэрэлтэх тэмдгийг байрлуулахад тавих шаардлага”-ын 6.6 дэх заалт	Гэрэлтэгч тэмдгийг аврах хэрэгсэл, гал түймэр унтраах анхан шатны хэрэгсэл, ослын эсрэг хамгаалах хэрэгсэл, мэдээлэл түгээх объект, хувийн хамгаалах хэрэгсэл гэх мэт бусад төрлийн авралтын хэрэгслийн ойр орчим байрлуулсан эсэх.				

Тайлбар: Хяналт шалгалтын хуудсанд давхацсан асуултыг харьяалах хуулийн заалтын дагуу шийдвэрлэнэ.

3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг,	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан	Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын
--	---	--

<i>тэмдэг</i>	<i>тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>үсэг, тэмдэг</i>
<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>
<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>

ТАЙЛБАР:

.....
.....
.....